



## ***МЭНДЧИЛГЭЭ***

Монгол улсад хоршооллын хөдөлгөөн үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Хөдөө аж ахуйн салбарын үе үеийн хоршоологчид, ажиллагсад, биднийг байнга дэмжиж, хамтран ажилладаг дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олонд ойн баярын мэндийг дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа 1921 оны 12 дугаар сарын 16-ны өдөр анхны эд хэрэглэгчдийн хоршоо 18 гишүүнтэйгээр байгуулагдаж, 1920-иод оны сүүлчээр ядуу лам нарыг нэгтгэж артель байгуулсан нь үйлдвэрлэлийн хоршооны эхлэл байсан. 1930-иад оны дунд үеэр Ардын үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдаж эхэлснээр хөдөө аж ахуйд хоршоолох хөдөлгөөн өрнөж 30 шахам жилийн дотор хувийн аж ахуйтнуудыг бүхэлд нь хамарсан байна. Тухайн үеийн нам засгаас хоршоолох үйл явцыг боловсон хүчин, санхүү эдийн засаг, техник технологи, бараа материалын зэрэг бүхий л хэлбэрээр дэмжин туслаж, ухуулга сурталчилгааны ажлыг эрчимтэй явуулж, жижиг нэгдлийг томруулах, өөр хооронд нь нэгтгэж зохион байгуулах замаар орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж болох сум бүрт нэг нэгдэлтэй байх бодлогыг явуулсан нь амжилттай хэрэгжсэн юм.

Монголын хөдөөг нэгдэлжүүлэн хоршоолох хөдөлгөөнийг тухайн үеийн улс төрийн эрх баригч хүчин болох МАХН, түүний ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал хошуучлан удирдаж хэрэгжүүлсэн ба тэрээр хожим бичихдээ “Монгол оронд нэгдэлжих хөдөлгөөн ялсан нь 1921 оны ардын хувьсгалтай эн тэнцэхүйц үйл явдал болсон” хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг.

Хөдөө аж ахуйн нэгдлийг аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлэх, чадварлаг боловсон хүчнээр хангахад тухайн үеийн нам, төрийн байгууллагууд онцгой ач холбогдол өгч олон чухал шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжүүлэх үйл явцад нь ихээхэн анхааралтай хандаж байжээ. Ийнхүү хоршооллыг хөгжүүлэх бодлого эрчимтэй явуулснаар эд хэрэглээний, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн гэсэн хоршооллын нэгдсэн систем бий болж тогтсон юм. Эдгээр тулгын гурван чулуу болсон хоршооллын байгууллагаас хамрах хүрээ, улс орны нийгэм, эдийн засагт эзлэх байр суурь илүүтэй нь Хөдөө аж ахуйн хоршоолол /нэгдэл/ байсан билээ.

Хөдөө аж ахуйн нэгдэл нь Монгол орны хөдөө нутгийн нүүр царайг бүхэлд нь өөрчлөн их бүтээн байгуулалтыг өрнүүлэн соёл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хөгжих үндсэн нөхцлийг бүрдүүлж, хүн амаа эрүүлжүүлэх, бүх нийтийн боловсрол олгоход үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Түүнчлэн мал аж ахуйг эрчимжүүлэн

үүлдэр угсааг сайжруулж, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрэн нэвтрүүлж чадсан юм. Энэ бүхнийг амжилттай хэрэгжүүлэхэд тухайн үеийн Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөл онцгой үүрэг гүйцэтгэсэн.

1992 оны 1 дүгээр сард хуралдсан Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн IX их хурлаас шинэчлэгдэн зохион байгуулагдсан Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо нь хоршооллын хөгжлийг эрчимжүүлж, хоршооллын байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар тогтвортой хөгжлийн суурийг бий болгож, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг бие даасан төрийн бус байгууллага юм.

Өнөөдөр үндэсний холбоо нь 21 аймагт гишүүн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, 400 гаруй анхан шатны хоршоод, 8 дундын хоршоотойгоор улсын хэмжээнд 110 гаруй мянган гишүүнтэй, 300 мянган хүнд хамтын аж ахуйн үр шимийг хүртээж, 290 гаруй сум суурингийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, улс орон даяар өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулж, Монгол улсыг Олон Улсын Хоршооллын Альянсад төлөөлөн ажилладаг байгууллага болж өргөжин тэлсээр байна.

Өнөөдөр бидний дунд Монгол улсын хөдөлмөрийн баатар, ахмад хоршоологч Н.Намжиг, Б.Лувсан, У.Доржпалам, Б.Доржсамбуу, Гавъяат эдийн засагч Ү.Цэдэнбал, Н.Дэрийлаа, М.Намжил, Ш.Тогоо, Б.Авирмэд, Байгаль орчны гавъяат ажилтан Д.Цэндсүрэн, Гавъяат нэгдэлчин Г.Галтай зэрэг хоршооллын салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан гавъяат үйлстнүүд ажиллаж амьдарч байгаад бид бахархаж явдаг.

Сүүлийн жилүүдэд хоршооллын үүрэг, ач холбогдолыг нийгмийн бүхий л шатанд ойлгож Монгол Улсын Их Хурал, Засгийн Газраас энэ салбарыг дэмжиж тусгайлсан бодлого хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал үндэсний хөтөлбөр”, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийг батлан гаргаж, эдгээр хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь хөдөө аж ахуйн хоршоо байхаар тунхагласан нь хоршооллын салбарыг дэмжсэн томоохон алхам болсон юм.

Төр засгаас авч хэрэгжүүлж байгаа энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд манай хөдөө аж ахуйн хоршооллын салбарын нийт ажилтан, хоршоологчид Та бүхний нөр их хөдөлмөр, хамтын ажиллагаа чиглэгдэнэ гэдэгт итгэл төгс байна. Хоршооллын хөгжлийг шинэ түвшинд гаргаж, орчин үеийн зах зээлийн нийтлэг чиг хандлагад нийцүүлэн, сонгодог утгаар нь хөгжүүлэх зорилт бидний өмнө тавигдаж байна.

НҮБ-аас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарласнаар дэлхий дахинаа олон чухал ажил өрнөж байгаа бөгөөд түүнд Олон улсын хоршооллын альянсын гишүүн байгууллагын хувьд манай байгууллага идэвхитэй оролцож байна. Тухайлбал НҮБ дээр өнгөрсөн 10 дугаар сард зохион байгуулсан “Олон улсын хоршооллын жил”-ийн нээлтэнд Дорноговь аймгийн Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Холбооны дарга Г.Ганбаатар, 11 дүгээр сарын 4-6 ны хооронд Тайвань улсад болсон Зүүн Азийн Хөдөө Аж Ахуйн Байгууллагуудын дээд хэмжээний уулзалтанд Хяналтын зөвлөлийн дарга А.Бакей, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Алтантуяа нар Монголын хөдөө аж ахуйн салбарын хоршоологчдоо төлөөлөн оролцлоо.

Мексик улсын Канкун хотод болж байгаа Олон Улсын Хоршооллын Альянсын Их хурал болон “Олон улсын хоршооллын жил”-ийн албан ёсны нээлтийн арга хэмжээнд Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбооны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан тэргүүтэй төлөөлөгчид Монгол орноо төлөөлөн оролцож байна.

НҮБ-аас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарлахад Монгол Улсын Засгийн Газар чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд өнөөдөр хоршооллын салбар Монгол орны төдийгүй дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа нь манай үе үеийн хоршоологчдын олон арван жилийн мятрашгүй хөдөлмөр, зүтгэлийн бодит илэрхийлэл юм.

*Эрхэм хүндэт хоршоологчид Та бүхнийг хоршооллын 90 жилийн ойгоо арвин их амжилт бүтээлээр угтаж, Олон улсын хоршооллын жилдээ ажлын өндөр амжилт гаргахыг хүсье.*

*Сайн үйлс дэлгэрэх болтугай.*

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

